



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/442

Хэрлэн сум

Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.3, 60.1.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гуравдугаар хуралдааны 05 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг, дэмжлэг үзүүлэх “Нутгийн ирээдүй” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай 06 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нутгийн ирээдүй хөтөлбөрийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэдийн сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

А.Жаргалсайхан Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Н.Батбаяр Аймгийн Засаг даргын зөвлөх

Б.Золбоо Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Д.Батхүү Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Н.Үнэнбат Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Д.Баярхүү Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичиг:

Б.Түмэнжаргал Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

2. Нутгийн ирээдүй хөтөлбөрийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамтрагдах хүсэлт ирүүлсэн иргэдийн сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

